

**АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2020 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
САЙНЦАГААН СУМАНД ХАМААРАЛТАЙ ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТ**

2020.12.01

НЭГ. ЗАСАГЛАЛЫН ХҮРЭЭНД

Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, хууль ёсыг бэхжүүлэхэд анхаарна.

№	Дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдсан эсэх	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин Үр дүн	Хэрэгжилт	Хувь
1	2	3	4	5	6	7
Зорилт 1.Төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр						
1.1.2	АЗДҮАХ 1.1.6	Унаагүй байгаа багийн Засаг дарга нарын унааны асуудлыг үе шаттай шийдвэрлэх	нэмэгдүүлсэн хувиар	90	Тус сумын багийн засаг дарга нарын 77.7% нь мотоциклиор хангагдаж, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэж байна.	70
1.1.3	ЗГҮАХ АЗДҮАХ 1.1.8	Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх замаар иргэдэд нээлттэй, ил тод шуурхай хүртээмжтэй, үйлчилгээг хүнд сурталгүй хүргэх, цахим засаглалыг бодитойгоор хэрэгжүүлэх	Төрийн цахим үйлчилгээний Хур системийг нэвтрүүлсэн сумдын тоо	6	“ХУР”системийг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээний хүсэлтийн бүртгэлийн хяналтын системээр нийт 379 иргэнд үйлчилгээ үзүүллээ. Үүнд: хууль сахиулах-352, иргэн-8, даатгал-7, үл хөдлөх-4, жолоодох эрх-6, гэрлэлт-1, тодорхойлолт-1 ийг гаргасан байна.	70
1.1.4	АЗДҮАХ 1.1.9	Иргэд, малчдын аюулгүй орчинд ажиллаж, амьдрах, мэдээллээр ханган, сум, багийнхаа үйл ажиллагаанд жигд оролцох боломжоор хангах	АС цогцолборыг орон тооны ажилтантай болгох, үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувиар	100	Төрийн албан хаагч сургууль, цэцэрлэгүүд 51 удаагийн мэдээллээр иргэд, 285 малчин өрх байгалийн гэнэтийн аюул, гамшгаас сэргийлэх болон хууль тогтоомжийн мэдээлэл хүргэлээ.	70
1.1.5	АЗДҮАХ 1.1.11	“Иргэдээ сонсьё” нэгдсэн өдөрлөг арга хэмжээг өргөтгөсөн хэлбэрээр зохион байгуулах	Төрийн үйлчилгээ авсан иргэдийн тоо	3000	Бүх нийтийн бэлэн байдал зарласантай холбогдуулан хийгдээгүй.	-
1.1.7	АЗДҮАХ 1.4.4	Гамшгаас хамгаалах Команд штаб, Засаг даргын нэрэмжит гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг зохион байгуулах	, Сайнцагаан, Луус сумд хэрэгжилтийн хувиар	100	Бүх нийтийн бэлэн байдал зарласантай холбогдуулан хийгдээгүй.	-
1.1.10	ЗГ-ын 234-р тогтоол АЗДҮАХ 1.1.8	Төр, Улаан загалмайн нийгэмлэгийн хамтын ажиллагааг дэмжиж ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	100	Улаан Загалмайн Нийгэмлэгийн үйл ажиллагааг дэмжин засаг даргын нөөцийн зардлаас 300.000 төгрөг зарцууллаа. УЗН-ээс Хөдөөгийн 4 багийн 128 өрхийн 528 иргэнд тусламжийн зүйл олголоо.	100
1.2.Хууль ёсыг бэхжүүлэх чиглэлээр						

1.2.1	АЗДҮАХ 1.2.2, 1.2.3	“Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг төлөвлөн, сумын “Эрх зүйн хөтөч” нарыг удирдлагаар хангаж, хамтран хэрэгжүүлэх	-Хөтөлбөрийн 2020 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар -Эрх зүйн хөтөч нарын сургалтанд хамрагдсан хувиар	100	Сумын ЗДТГ, эрх зүйн хөтөч цахим группээр цахим 2 аяны бичлэг, хууль зүйн луужин пейж хуудасны танилцуулга, www.E-KHUTUCH цахим хуудасны танилцуулга зэрэг богино хэмжээний видео шторкыг иргэдэд хүргэж, Хүүхэд хамгааллын тухай хуулийн цахим сургалтыг байршууллаа. Сумын ЭМТөвийн хүлээлгийн хэсгийн ТВ-ээр хуулийн видео танилцуулга явуулж, гарын авлагыг 128 иргэнд хүргэлээ. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн видео хичээлийг ЗДТГазар пейж хуудсанд байршуулан 593 иргэн үзэж, 38 иргэн шэйр хийлээ. Мөн 253 өрхөөр айлчилж, 3 хууль, 5 зөвлөмжийг насанд хүрэгчид 388, бага насны 83, өсвөр насны 67 хүүхдэд хүргэлээ. Mandal school 2015 нээлттэй группт хуулийг 7 хоног бүр сурталчилан нийт 2100 иргэн танилцлаа. Covid-19 өвчлөлийн талаар иргэдэд багуудын пэйж хуудас, Сайнцагаан ЗДТГазрын пэйж хуудас болон гарын авлагыг 180 иргэнд тараалаа.	70
1.2.2	АЗДҮАХ 1.2.4	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2020-2023)-ийн II үе шатны ажлыг төлөвлөн, ИНБайгууллагатай хамтран хэрэгжүүлж, нийтийн албанд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, шударга байдлын түвшний үнэлгээг нэмэгдүүлэх	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 2020 оны хэрэгжилтийг улсын дунджаас бууруулахгүй байх хувиар Шударга байдлын түвшний үнэлгээ ахисан хувиар	80	Энэ онд ЕБСургуулийн сургалтын менежер 4, сургуулийн захирал 1, цэцэрлэгийн эрхлэгч 1, багийн засаг дарга 5 нийт 11 албан тушаалтны ХАСУМ-ийг цахимаар хянуулан, хуулийн хугацаанд ХАСХОМ-ийг гаргууллаа. Ажлын байрны томилгооны зөрчилгүй ажиллаж, ХАСХОМ гаргагч нар 2019 оны мэдүүлгээ хуулийн хугацаанд цахимаар гаргалаа. Авилга ашиг сонирхолтой холбоотой зөрчил гомдол гараагүй болно.	100
1.3. Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр:						
1.3.1	АЗДҮАХ 1.3.2,	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдэд эрх зүйн туслалцаа, зөвлөгөө мэдээлэл өгөх нэгдсэн болон хэсэгчилсэн ажил, арга хэмжээг зохион байгуулж, үр нөлөөг нэмэгдүүлэх	ГХУСэргийлэх үйл ажиллагааны аймгийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувиар	100	Иргэдэд цагдаагийн төлөөлөгчтэй хамтран 1 удаа сургалтыг зохион байгуулж, 1082 иргэн хамрагдлаа. Гэмт хэргийн гаралт өмнөх онтой харьцуулахад 5 буюу 0.9 хувиар буурсан байна.	70
			Гэмт хэрэг, зөрчлийн бууралтын хувиар	10		
1.3.2	АЗДҮАХ 1.3.4	“Архидалтгүй аймаг– Дундговь” (2018-2020) аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд иргэд, олон нийтийг соён гэгээрүүлэх ажлын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх	-Зохион байгуулсан арга хэмжээ -Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн бууралтын хувиар	10	“Сархадгүй Сайнцагаан” хэсэгчилсэн арга хэмжээг иргэдэд танилцуулга хуудас болон цахим хэлбэрээр хийлээ. Сумын хэмжээнд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 32 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.	70

1.3.4	АЗДҮАХ 1.3.5	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийг гэмт хэрэг, осол зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэхэд бүх шатны төрийн болон төрийн бус байгууллагуудыг татан оролцуулж, сэтгэл зүйн тусламж, дэмжлэг үзүүлэх танхимтай болгож, үйл ажиллагааг нь тогтмолжуулах	Хүүхдээс үйлдсэн гэмт хэрэг, зөрчил болон гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэг зөрчлийн буурсан хувиар	10	Цагдаагийн газар, Оюуны гэгээ ТББ, сумын ИТХурал хамтран “Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хамтдаа”, цахим аяныг “Харуусал биш хайр өвлүүлье” уриан доор зохион байгууллаа. Аяны хүрээнд 12 постер, 19 видео мэдээллийг цахимд байршуулж, хүчирхийлэлд өртөж болзошгүй хүүхэд 37, өрх , гэр бүлийн хүчирхийлэлтэй 14 айл өрхөөр айлчилж, нөхцөл байдалтай танилцлаа. 2020 онд цагдаагийн байгууллагаар шалгагдсан гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 20 иргэний гэр бүлд нөхцөл байдлын үнэлгээ хийж, нийгмийн ажлын үйлчилгээг хамтарсан багаар ажиллан, гэр бүлд хууль эрх зүйн зөвлөгөө, зөвлөмж, хүчирхийлэл үйлдэгчдээс амлалт авлаа.Өмнөх онтой харьцуулахад 9 кейс буюу 45%-иар өссөн байна.	70
1.3.5	АЗДҮАХ 1.3.7	Малчдын бүлэг, нөхөрлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр бүсчилсэн зөвлөгөөн, семинар зохион байгуулж, тодорхой шийдвэр гаргаж, мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх	Мал хулгайлах гэмт хэрэг буурсан хувиар	5	Сумын малчин өрхүүдийн дунд 1 сарын хугацаатай аяны богц аялуулж, малын хулгайн гэмт хэргийн мэдээлэл, гарын авлага 200 ширхэг тарааж, танилцуулга мэдээллийг цахимаар хүргэлээ. Цахимд 23 өрхийн 157 иргэний хандалттай байна. Малын хулгайн гэмт хэрэг өмнөх оноос 26,3 хувь буурсан байна.	70
Хэрэгжилт-76%						

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭНД

Эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулна.

№	Дунд хугацааны бодлогын баримт бичиг	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүн	Шаардлагатай хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /сая төгрөгөөр/	Хувь
2.1. Эдийн засгийг нэмэгдүүлэх чиглэлээр:						
2.1.1	АЗДҮАХ 2.1.1 Гурван тулгуур хөгжлийн бодлого 3.1.2.9	Салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, үнэ цэнийн сүлжээ, кластерийг хөгжүүлэх ур чадвар эзэмшүүлэх сургалт, зах зээлийг өргөтгөх боруулалтын сүлжээг дэмжих замаар эдийн засагт жижиг, дунд үйлдвэрийн эзлэх байр суурийг бэхжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэх	Аж ахуй эрхлэлтийн ур чадварыг эзэмшүүлэх мэдлэг олгох, төсөл боловсруулах сургалтын тоо	4	Энэ онд 4 чиглэлээр 9 төрлийн 18 зээлд 466,740 төгрөгний зээл олголоо.Дээрх бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэн ААНэгжүүдэд олгосон зээлийн 7 төсөл нь тэдний тогтвортой байдлыг сайжруулахад дэмжиж олгосноор 26 ажлын байр хадгалагдаж, шинээр 69 байнгын болон түр ажлын байрыг бий болсон нь өмнөх оноос 42-оор нэмэгдлээ.Цаг үеийн байдлаас болж сургалт явагдаагүй.	70
			Сургалтад хамрагдсан нийт иргэдийн тоо	150		
2.2 Төсөв санхүүгийн чиглэлээр:						
2.2.4		Хүн ам, орон сууцны тооллого зохион байгуулах	Хүн ам, орон сууцны тооллогыг аймаг,	100	Хүн ам орон сууцны 2020 оны ээлжит тооллогод нийт 500 өрх сонгогдон / Наран баг-25, Тэвш баг-25, Далай баг-30,	100

			суманд зохион байгуулах хувиар		Үйзэн баг-30, Арвижих баг-60, Боржигон баг-60, Нарлаг баг-115, Айраг баг-70, Мандал баг-85 өрх тоологдлоо.	
Хэрэгжилт-85%						

ГУРАВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Иргэдийн эрүүл аюулгүй орчинд сурч, хөгжих, ажиллаж, амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлж, нийгмийн үйлчилгээнд тэгш хүртээмжтэй хамрагдах боломжийг бий болгох замаар хүний хөгжлийг хангаж, нийгмийн баталгааг нь сайжруулна.

№	Дунд хугацааны бодлогын баримт бичиг	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүн	Шаардлагатай хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /сая төгрөгөөр/	Хувь
1	2	3	4	5	6	7
3.1 Эрүүл мэндийн чиглэлээр						
3.1.3	АЗДҮА-ийн хөтөлбөрийн 3.1.1	“Тэмбүүг устгая” 2020 оны арга хэмжээг аймгийн хэмжээнд зохион байгуулах	Үзлэгийн тоо	15	Бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэгт 703 иргэнийг хамрууллаа. Үүнээс тэмбүү 15, заг хүйтэн 12, триханоз 5-ийг илрүүлж аймгийн нэгдсэн эмнэлгийн БЗДХалдвартын кабинетаар эмчлүүлээ.	70
			Эрсдэлт болон хавьтлын үзлэг	50		
			оношлогооны хамрагдалтын хувь	100		
3.2 Боловсролын чиглэлээр						
3.2.1	АЗДҮАХ 3.2.4.	Бүх сургуульд Байгалийн ухааны хичээлийн кабинет байгуулж, туршилтат хичээл явуулах боломжийг бүрдүүлэх	Шинэ кабинеттай болсон ЕБ-ын сургуулийн тоо	13	Сумын Ерөнхий боловсролын 5 сургууль БСШУСЯ-ны хөрөнгө оруулалтаар байгалийн ухааны кабинетуудаа 60,2 сая төгрөгийн хичээлийн хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр хангаж, туршилт хичээл явуулах орчин нөхцөлийг бүрдүүллээ. Мандал сургууль БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар хими кабинетад 80 төрлийн 1721 ширхэг хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийг 10,7 сая төгрөг, ГИЦСургууль Бага сургуульдаа “Туршиж үзээд, тунгаан бодъё” төслийн хүрээнд Дэлхийн банк, БШУЯ, БЧШ хамтарсан 15240000 төгрөгийн хөрөнгө оруулалтаар байгалийн ухааны кабинет байгууллаа. Шинээр 2 сургууль байгалийн ухааны кабинет байгууллаа.	100
3.6 Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын чиглэлээр						
3.6.2	АЗДҮАХ 3.6.13	Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай	Сонгогдсон өрхийн тоогоор	35	Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай 35 өрхөөс ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 6 өрхийг хамруулан 22,5 сая төгрөгний	70

		сумын өрх иргэдийг Төрийн болон ТББ, ААНэгж байгууллагад квотоор хуваарилан амьжиргаанд нь дэмжлэг үзүүлэх	Амьжиргааны түвшинд нь ахиц гарсан өрхийн хувь	20	санхүүжилт олголоо. Байнгын ажлын байранд 1, нийтийг хамарсан ажилд 3, түр ажлын байранд 3 иргэнийг хамрууллаа. Шинээр 2 өрхийн 11 иргэнийг хүнсний эрхийн бичгийн хөтөлбөрт хамрууллаа. Грийн мэпл компаниас ахмад настан 1, хөгжлийн бэрхшээлтэй 6 иргэнд 139000 төгрөгний тусгай хэрэгсэл олголоо. Амьжиргааны түвшинд 21% ахиц гарлаа.	
Хэрэгжилт-80%						

ДӨРӨВ. ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ, ГАЗАР ТАРИАЛАН, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХҮРЭЭНД

Бэлчээрийн менежментийг сайжруулан ажиллана.

№	Дунд хугацааны бодлогын баримт бичиг	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүн	Шаардлагатай хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /сая төгрөгөөр/	Хувь
1	2	3	4	5	6	7
Зорилт 1.Хүнс хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн хүрээнд						
Газар тариалангийн чиглэлээр						
4.1.1	АЗДҮАХ 4.1.16 Гурван тулгуурт хөгжлийн бодлого 3.1.1.20	Хүлэмжийн аж ахуйг дэмжиж, таримлын нэр төрлийг олшруулж, нэгж талбайгаас авах ургацыг нэмэгдүүлэн хүн амыг шинэ ургацын хүнсний ногоогоор ханган ажиллах	Хүлэмжийн тариалсан талбайг м2-аар нэмэгдүүлсэн байх	300 ^{м2}	Хүлэмжийн тариалалтын талбайг өмнөх оноос 0,120 мв-аар ахиулж ургацын хэмжээг 4,2 тн-оор нэмэгдүүлж, 1.2500 мкв талбайгаас 7 нэр төрлийн 15,285 тн жүлэмжийн ногоог хураан авсан байна. Байнгын ажиллагаатай өвлийн нарлаг хүлэмжийн тариалалтыг СХС-аас 28,5 сая төгрөгөөр дэмжиж, өвлийн хүлэмжийн талбайг өмнөх оноос 120 мкв-аар, таримлын төрлийг 3-4 нэр төрлөөр тус тус нэмэгдүүллээ.	100
			Хураан авах ургацын хэмжээг урьд оноос нэмэгдүүлэх хэмжээ / тн/	5		
			Хүн амыг шинэ ургацын хүнсний ногоогоор хангах /өмнөх оноос нэмэгдүүлсэн хувиар/	1,2		
4.1.2	ЗГ-ын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр	Тариалан эрхлэгчдийг төсөл хөтөлбөрт хамруулан хөнгөлөлттэй нөхцлөөр хүлэмж, үр бордоогоор хангаж, тариалалтын талбайг нэмэгдүүлэх	Төсөл хөтөлбөрт хамрагдах тариалан эрхлэгчийн тоог нэмэгдүүлэх	5	Энэ онд 5.7 га-д төмс тариалж, 72,4 тн , 4,3 га-д 19 нэр төрлийн хүнсний ногоог тариалж, 54,9 тн, 14,1 га талбайд тариалагдсан жимс, жимсгэний бутнаас 0,9 тн жимс жимсгэнэ нийт 128,2 тн ургацыг хураан авсан нь өмнөх оноос 18,6 тн-оор нэмэгдлээ. Тариалан эрхлэгч 38 иргэнд 349 100 төгрөгийн 4 төрлийн үрийг олгож, 3 иргэнийг СХС-ийн хөнгөлөлттэй зээлд хамруулж 67 сая төгрөгөөр дэмжлээ.	100
			Төмс, хүнсний ногоог тариалах хэмжээ /га/	38		
			Төмс, хүнсний ногоо хураан авах ургацын хэмжээ / тн/	228		
4.2 Мал аж ахуйн салбарын чиглэлээр						
4.2.1	АЗДҮАХ	Бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг зохион	Авч хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийн хувиар	80	Үлийн цагаан, чичүүл оготнотой 5 мянган га бэлчээрт энгийн механик аргаар 11 иргэн, 6 техник ажиллан	100

	4.1.4.	байгуулах	Хамруулах талбайн хэмжээ / мян/га/	50	7999.740 төгрөг, микробиологийн аргаар 2 мянган га-д 10 иргэн, 9 техник ажиллан 28501311 төгрөг тус тус зарцуулллаа.	
4.2.3	АЗДҮАХ 4.1.6	Гүн өрмийн худгийг шинээр гаргах болон сэргээн засварлах, энгийн уурхайн худгийг сэргээн засварлаж усан хангамжийг нэмэгдүүлэх	Аймгийн хэмжээнд шинээр гаргах гүн өрмийн худгийн тоо	10	Сумын ОНХС-ийн 16 сая төгрөгийн санхүүжилтээр энгийн уурхайн 8 худгийг засварлалаа. Улсын төсвийн хөрөнгөөр инженерийн 3 худаг гаргах тендерийн шалгаруулалт аймагт хийгдэж байна.	70
			Энгийн уурхайн худгийг сэргээн засварлах тоо	15		
4.2.4	АЗДҮАХ 4.2.2.	Дундговийн айраг, ингэний хоормогийг орон нутгийн брэнд бүтээгдэхүүн болгон баталгаажуулж зах зээлд нийлүүлэх	Гүүний айраг, ингэний хоормог үйлдвэрлэдэг сумдыг хамруулах	4	Хийгдээгүй	-
			Брэнд бүтээгдэхүүний тоог нэмэгдүүлсэн байх	2		
4.3 Мал эмнэлгийн чиглэлээр						
4.3.2	АЗДҮАХ 4.1.12 Гурван тулгуурт хөгжлийн бодлого 3.1.1.5	Бруцеллөз өвчинтэй тэмцэх стратегийг хэрэгжүүлж тандалт вакцинжуулалт ийлдсийн тандалт хийх	Бруцеллөзын шинжилгээнд хамрагдах хээлтүүлэгчийн тоо /давхардсан тоогоор сая толгой /	18,0	Бруцеллөзын шинжилгээнд 275 хуц, 150 ухна нийт 425 хээлтүүлэгч хамрагдсанаас 7 хуц,3 ухна эерэг /өвчтэй/ гарсан тул холбогдох арга хэмжээ авлаа. Бруцеллөзын дархлаажуулалтанд богийн 46275 охин төл, 358 охин тугал бүгд 46633 охин төл хамруулж 99,6% гүйцэтгэлтэй хийгдсэн.	100
4.3.3			Вакцинжуулалтад хамрагдах төлийн тоо /мян/	600		
4.4 Үйлдвэрлэл үйлчилгээ, хүнс худалдааны чиглэлээр						
4.4.1	АЗДҮАХ 4.2.7	“Дундговь түншлэл 2020” үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, бүс, улсын болон олон улсын үзэсгэлэн худалдаанд оролцогчдод дэмжлэг үзүүлэх#	“Дундговь түншлэл-2019” үзэсгэлэн худалдаанд 120 иргэн, ААН оролцсоныг нэмэгдүүлэх хувиар	10	“Дундговь түншлэл-2020” үзэсгэлэн худалдаанд тус сумаас 43 аж ахуй нэгж иргэн, 15 сая төгрөгний борлуулалт хийсэн байна. Аж үйлдвэрийн шилдэг бүтээгдэхүүн номинацад: иргэн Б.Долгорсүрэн Шилдэг гар урлалын болон бэлэг дурсгалын бүтээгдэхүүн номинацад: иргэн М.Мөнхнасан Б.Эрдэнэтогоос Нийтийн хоолны салбарын шилдэг үйлдвэрлэгч байгууллага номинацад: “Ээлт бор хайрхан” ХХК тус тус шалгарлаа.	100
			Борлуулалтын орлогыг 43,2 сая байсныг нэмэгдүүлэх хувиар	10		
Хэрэгжилт-95%						

ТАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, УУЛ УУРХАЙН ХҮРЭЭНД

Байгалийн нөөцийг зохистой ашиглаж, байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг шинэ шатанд гаргаж, аялал жуулчлал, уул уурхайгаас орон нутагт орох орлогын хэмжээг нэмэгдүүлнэ.

№	Дунд хугацааны бодлогын баримт бичиг	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Зорилт от түвшин, үр дүн	Шаардлагатай хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /сая төгрөгөөр/	Хувь
---	--------------------------------------	-------------	------------------	--------------------------	--	------

5.1. Аялал жуулчлалын чиглэлээр

5.1.2	ЗГҮАХ-ийн 4.4.2 дахь заалт АЗДҮАХ 5.2.2	Жуулчдад үзүүлэх уламжлалт зан заншил, нутгийн онцлогийг харуулсан “Хотод ойрхон говь” /эвент арга хэмжээг зохион байгуулж, гадаад, дотоод жуулчдын тоог нэмэгдүүлэх	Аймгийн төвд ТХДЖТ-ын тоглолт, “Шөнийн Музей” арга хэмжээ Цагаан суваргад “Тэмээний баяр” Онгийн хийдэд “Малчны баяр, Ардын урлагийн наадам” Бага газрын чулууны ууланд “Адуу, айрагны баяр” эвент арга хэмжээнүүдээс зохион байгуулах тоо	1-2	Цаг үеийн байдлаас шалтгаалан хийгдээгүй.	-
			Гадаад, дотоод жуулчдын тоог өмнөх оноос нэмэгдүүлэх хувиар	5		

5.2. Ашигт малтмал, уул уурхайн чиглэлээр

5.2.2		Ашигт малтмал хулгайгаар олборлох асуудлыг таслан зогсоох ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах	Ашигт малтмалыг хулгайгаар олборлох асуудлын шийдвэрлэлт /хувь/	70	Аймгийн Цагдаагийн газартай хамтран Үйзэн багийн Төгрөг хэмээх газар хууль бус жонш олборлосон 5 үйлдлийг таслан зогсоож, 9 иргэнд 1.800.000 төгрөгний торгууль ногдууллаа.	70
-------	--	---	---	----	---	----

Хэрэгжилт-70%

ЗУРГАА. БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХҮРЭЭНД

Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлыг аймаг, сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тулгуурлаж, хүн ардын ая тухтай ажиллах, амьдрах нөхцөлийг сайжруулахад чиглүүлнэ.

№	Дунд хугацааны бодлогын баримт бичиг	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Зорилт от түвшин, үр дүн	Шаардлагатай хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /сая төгрөгөөр/	Хувь
6.1.1	АЗДҮАХ 6.2.3-12	Аймгийн төвийн 2,8 км хатуу хучилттай авто замыг ашиглалтад оруулах.	ажлын хувиар гүйцэтгэлийн	90	Аймгийн төвийн 2,8 км хатуу хучилттай авто замын барилга угсралтын ажлыг улсын төсвийн 2,176.0 сая төгрөгийн хөрөнгөөр "Дэвжих-Эрдэнэ" ХХКомпани 90%-тай гүйцэтгэж байна.	100

6.1.2	АЗДҮАХ 6.1.5-10	Говийн ирээдүй цогцолбор сургуулийн спорт заалны барилгыг дуусгах	барилга байгууламжийн угсралтын ажлын гүйцэтгэлийн хувиар	100	Хийгдээгүй	-
6.1.4	АЗДҮАХ 6.1.4, 6.2.14	Сайнцагаан сумын Далай хорооллын 0.4кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын ажил, төвийн Мандал, Айраг, Аривжих багийн гэр хорооллын гэрэлтүүлгийн ажил, Залуус хорооллын нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилтын ажил	9 төсөл арга хэмээний барилга байгууламжийн угсралт, тохижилтын ажлын гүйцэтгэлийн хувиар	80	Далай хорооллын 0,4 КВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын зураг, төсвийг мэргэжлийн байгууллагаар хийлгэж улсын магадлах комиссоор орох шатандаа явж байна.	40
6.1.5	АЗДҮАХ 6.2.6-8	Аймгийн төвийн 5, 12-р орон сууцны гадна фасадны ажил хийж дуусгах	8 төсөл арга хэмжээний барилга байгууламжийн засварын ажлын гүйцэтгэлийн хувиар	80	ОНХСангийн 165,966,186 төгрөгний хөрөнгөөр "Сүлд оюу хайрхан" ХХКомпани 5, 12-р байрны фасад, явган зам, хүүхдийн тоглоомын талбайн ажлыг гүйцэтгэлээ.	100
		Аймгийн төвийн Дулааны станцын 2-р хэлхээний шугам, сүлжээний зураг төсөв, Сайнцагаан сумын 6, 7, 8 байрны гадна фасад, тохижилт, дээврийн зураг, төсөв боловсруулах, 15, 18 байрны дээврийн зураг, төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг хүлээн авах.	4 төсөл арга хэмжээний зөвлөх үйлчилгээний ажлыг хүлээн авах хувиар	100	Аймгийн төвийн дулааны станцын 2-р хэлхээний шугам сүлжээний зураг төсвийн гүйцэтгэгчээр "Тэмжин" ХХК шалгаран улсын магадлах комиссоор орох шатандаа байна. 6,7,8-р байрны гадна фасад, тохижилт, дээврийн засварын зураг төсөл боловсруулах ажлын тендерийг 10 сарын 22-ны өдөр зарлаж,15,18-р байрны дээврийн зураг төсөв боловсруулах ажлыг "Зэдпрожент" ХХК нь гүйцэтгэн хүлээн авлаа.	70
6.1.7	АЗДҮАХ 6.2.11, 6.1.12	Шинээр баригдах цэвэрлэх байгууламжтай хамт гэр хорооллын гадна бохир усны шугамын ажлыг эхлүүлэх.	Ажлын гүйцэтгэлийн хувиар	10	Азийн хөгжлийн банкны 8,395,4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Мандалговь хотын цэвэрлэх байгууламж барих ажлыг "Сайн констракшин" ХХК, "Сан констракшин" ХХКомпаниуд гүйцэтгэж байна.	40
6.1.8	ЗГҮАХХА ХТ 2.81.5	Газар зүйн нэрийн хээрийн тодруулалт хийх, нэрийн мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг зохион байгуулан хүлээн авах	Нэрийн мэдээллийн санг үүсгэн сумдын ИТХ-аар батлуулах бэлтгэл ажлыг хангах ажлын гүйцэтгэлийн хувиар	100	Тус суманд ажлын хэсэг байгуулагдан,газар усны нэрийн тодруулга улсын хэмжээнд анх удаа мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулагдаж, хөдөөгийн багуудад 780 нэрийн тодруулга хийгдлээ	100
Хэрэгжилт-75%						
Нийт хэрэгжилт- 80.16%						

САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

